



СЭЛЭНГЭ АЙМГИЙН
ШААМАР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 15 өдөр

Дугаар А/087

Дэлгэрхаан

Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор
ажиллах, газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх,
таниулах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", 30 дугаар зүйлийн 30.1.6, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.7, Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоолоор батлагдсан "Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам", 2011 оны 340 дүгээр тогтоолоор батлагдсан "Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам", 2017 оны "Газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдөртэй болох тухай" 67 дугаар тогтоол, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2019 оны 03 сарын 15-ны өдрийн А/76 тоот захирамжийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын хэмжэнд газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдрийг 2019 оны 03 дугаар сарын 20-ны өдөр, гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулийг 2019 оны 03 сарын 21-ны өдрийн 16:00 цагт тус тус зохион байгуулсугай.


2.Дадлага сургуульд оролцох байгууллага, аж ахуйн нэгжийн нэрсийг нэгдүгээр хавсралтаар, Газар хөдлөлтийн гамшгийн аюулыг иргэд, олон нийтэд таниулах, гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах сургалт дадлага сургууль зохион байгуулах ажлын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, таниулах өдрийн хүрээнд газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх сэдэвт сургалтыг байгууллагуудын ажилтан албан хаагч нарт зохион байгуулахыг Байгаль хамгаалагч /Ж.Алтангэрэл/ -д үүрэг болгосугай.

4.Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор байгууллагын ажилтан албан хаагчид газар хөдлөлтийн үед байгууллагаас гарах дадлага сургууль зохион байгуулж ажиллахыг байгууллагын дарга, эрхлэгч нарт даалгасугай.

5. Газар хөдлөлтийн гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх таниулах өдрийг тэмдэглэн өнгөрүүлсэн ажлын тайлан, Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулийг зохион байгуулсан тухай тайланг нэгтгэн 2019 оны 03 сарын 22-ны өдөр Онцгой байдлын emer.selenge@yahoo.com хаягаар явуулахыг БОХУын байцаагч /Б.Онон/-д хариуцуулсугай.

ЗАСАГ ДАРГА



М.БАЯРБААТАР